



---

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА**

---

**НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН  
2024 ОНЫ 4-Р УЛИРЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

ОРХОН АЙМАГ

19

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ  
ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН 2024 ОНЫ 4-Р УЛИРЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 оны 12 дугаар сарын 31-ны өдөр

Орхон аймаг

№	Хөтөлбөрийн бодлого, зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан хаагч	Шаардагдах нөөц	Хүрсэн түвшин	Биелэлтийн хувь
<b>Арга хэмжээ 1. Албан хаагчдын амьдралын нөхцөлийг сайжруулах, тусламж дэмжлэг үзүүлэх хүрээнд</b>							
1	Цалин хөлс, шагнал урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Монгол улсын Засгийн газрын шинэчилсэн тогтоол шийдвэрийг үндэслэн цалин хөлсийг тогтоож, олгох	Тухай бүр	СХДАА-ны дарга Д.Сайзмаа, Ахлах мэргэжилтэн Л.Булганцэцэг	Үйл ажиллагааны зардал	Оны эхэнд Аймгийн Засаг даргын 2024.01.25-ны өдрийн А/60 дугаар захирамжаар удирдах ажилтны цалин хөлсний хэмжээг шинэчлэн тогтоосон ба албаны даргын 2024.01.02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар албан хаагчдын ажил, албан тушаалын жагсаалт, үндсэн цалингийн сүлжээ, бусад нэмэгдлийн хэмжээг шинэчлэн баталж 2024 онд 10 орон тоог баталж ажилласан. ЗГ-ын 2024 оны 128 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2024.04.08-ны өдрийн А/246 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний төрийн байгууллагын хавсралтад нэр тусгагдсан удирдах ажилтнуудын цалин хөлсний хэмжээг шинэчлэн тогтоож 2024.04.01-ны өдрөөс мөрдөж цалин хөлсийг олгож ирсэн байна.	100
		Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үнэлгээ, ажилласан жил, ур чадварын байдлыг харгалзан зэрэг дэв нэмэгдүүлэх				Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 1996 оны 63/104 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-д заасны дагуу албаны даргын 2024.01.02-ны өдрийн Б/01 дүгээр тушаалаар албаны нягтлан бодогч, Архив, бичиг хэргийн эрхлэгч нарт	100


					25%-иар тооцож 3 сарын хугацаанд олгосон ба нягтлан бодогчид 2-р улирлын байдлаар ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвхи санаачлагыг дэмжин 3 сарын хугацаанд албан тушаалын үндсэн цалингийн 20%-иар олгохоор шийдвэрлэж, нэмэгдлийг олгосон байна. Мөн Аймгийн Засаг даргын 2024.01.18-ны өдрийн Б/06 дугаар захирамжаар "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох" захирамжийн дагуу 4 албан хаагчид буюу 1 албан хаагчид тэргүүн зэрэг, ахлах түшмэл, 2 албан хаагчид тэргүүн зэрэг Дэс түшмэл, 1 албан хаагчид Дэд зэрэг Дэс түшмэлийн зэрэг дэвийг олгохоор шийдвэр гарч оны эхнээс олгож эхэлсэн байна.	
		Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж, үр дүнгийн урамшуулал олгох	Хагас бүтэн жилээр		Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг эхний хагас жилээр дүгнэж үр дүн урамшууллыг Албаны даргын 2024.06.25-ны өдрийн Б/14 дүгээр тушаалаар нийт 6 албан хаагчид 7,971.3 мянган төгрөгийг олгосон байна. 1-р улирлын байдлаар 40%-иар, 2-р улирлын байдлаар 50%-иар 4-р улирлын байдлаар 100% хүртэл тус тус урамшуулал олголоо.	100
		Албан хаагчдад хоол, унааны зардлыг сар бүр олгох	Сар бүр		Албаны даргын 2022.03.04-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хоолны зардалд 5000 төгрөгөөр олгож байсныг 2023.10.27-ны өдрийн А/27 дугаар тушаалаар Төрийн албаны ёс зүйн тухай хууль шинээр батлагдсан, албанд нэгдсэн менежментийн тогтолцоо хэрэгжиж байгаатай холбогдуулан Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлтийг 7.12-д заасан заалтаар оруулан хоол унааны мөнгийг 8500 төгрөг болгон олгохоор шийдвэрлэж, одоог хүртэл олгож байна. 2024 оны 12 сард хоол унааны мөнгийн 13.0 мянган төгрөг болгон нэмэгдүүлэхээр ажлын	100

						хэсэг ажиллаж дотоод журамд оруулахаар ажиллаж ирэх онд батлан мөрдөж ажиллана.	
		Албан хаагчдын ажлын үр дүнг харгалзан шагнал урамшуулалд тодорхойлох	Тухай бүр			МУЗГ-ын 2024.02.08-ны өдрийн 83 дугаар тогтоолоор "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу 5 жил буюу 60 сарын урамшуулалд 6 албан хаагчийг хамруулан нийт 39,394.6 мянган төгрөгийн урамшууллыг олгосон. Төрийн албан хаагчдын ажлын үр дүнг үнэлж дүгнэн үр дүн урамшууллыг хагас бүтэн жилээр олгосон.	100
		Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу албан хаагчдад нэг удаагийн тэтгэмж олгож дэмжлэг үзүүлэх	жилдээ			Албанд СХШУБ-аар ажиллаж байсан С.Идэрмөнх хүнд өвчний улмаас нас барсан тул холбогдох баримтыг үндэслэн албаны даргын тушаалаар нэг удаагийн буцалтгүй тусламж 500,0 мянган төгрөгийг түүний ар гэрт үзүүлсэн. Мөн байгууллагын удирдлагын зүгээс Төрийн албаны тухай хуулийн 60.2-т заасны дагуу 60 сарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 87,120.0 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгуулахаар Аймгийн Засаг дарга болон ЗДТГ-т хүсэлт гарган, АИТХ-аар шийдвэрлүүлсэн нь төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангаж, түүний ар гэрт томоохон дэмжлэг болж чадлаа. Хөдөлмөрийн дотоод журмын 7.8.5-д заасан заалтын дагуу 1 албан хаагчид шинэ байранд орсон тул 250,0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.	100
<b>Арга хэмжээ 2.Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах хүрээнд</b>							
2	Албан ажлын хэвийн хаагчдын байрны таатай	Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, бичиг хэргийн хэрэгсэлээр хангах		Дотоод аудитор-СХШУАБ	Үйл ажиллагааны зардал	Албаны бичиг хэргийн зардал сард 300.0 мянган төсөвлөгдөж 4-р улирлын байдлаар 4,000.0 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд зарцуулсан байна.	100

нөхцлийг бүрдүүлсэн байдал	Ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах (өрөө тасалгаа тохижилт, гэрэлтүүлэг, цахилгаан хангамж гэх мэт)	Тухай бүр	О.Болормаа	Ажлын байрны орчин нөхцлийг сайжруулах чиглэлээр нийт 8,118.6 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч албан хаагчдын өрөө тасалгааны тохижилтыг хийсэн байна. Үүнд: Албанд 2 дэлгэц, өнгөт принтер, 1 сандал худалдан авч ажлын байрны орчин нөхцлийг дээшлүүлсэн байна. Мөн 12 сард архив бичиг хэргийн өрөөний шалыг шинээр сольж өнгө үзэмжийг дээшлүүлсэн. Албаны удирдлага ОНӨГ-т хандаж шинээр 1 өрөөг шийдвэрлүүлэн хүлээн авч албан хаагчдын дэмжлэг тусалцаатайгаар /2 сая төгрөг/ засвар үйлчилгээ хийж өнгө төрхийг сайжруулан суух нөхцөл боломжийг бүрдүүлж өгсөн байна.	100
	Албан ажлын хэрэгцээ, ажил үүргээ гүйцэтгэхэд албаны унаагаар хангах			Албаны шатахууны зардал сард 300.0 мянган төсөвлөгдөж жилийн эцэст 3,600.0 мянган төгрөгийн түлш шатах тослох материалыг анхан шатны баримтаар зарцуулсан байна.	100
	Сургалтын төлөвлөгөөний дагуу албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавхижуулах, гадаад, дотоодод давтан сургах			Байгууллагын хэмжээнд байгууллагын соёлын зөв ойлголт, хандлагыг төлөвшүүлэх, байгууллагын соёлоо үнэлэх, цаашид эерэг хандлагыг түгээх чиглэлээр албан хаагчдыг сургалтад хамруулсан. Тус хөтөлбөрийн хэрэгжилтэд байгууллагаас 250.0 мянган төгрөгийн төсвийг зарцуулсан. Мөн 2024.05.14-нд "Гэр бүлийн үнэ цэн" сэдэвт сургалтад "Brain's not кофе шоп"-д албан хаагчдыг хамруулж, мэдээ мэдээлэл өгөв. 2024.09.24-нд Аймгийн ОБГ-аас гамшгийн аюулт үзэгдэл, эмзэг байдал, чадавхын ялгаа сэдэвт сургалтад албан хаагчдыг хамруулж мэдээ мэдээллээр хангаж ажилласан байна. Байгууллагын сургалтын төлөвлөгөөний дагуу албан хаагчдыг сургалтуудад тухай бүр нь хамруулсан.	100

						<p>Монгол улсын сангийн яамнаас ирүүлсэн албан бичигт "Монголын үндэсний Дотоод аудиторуудын холбоо" ТББ-аас 2024.11.14-ны өдөр зохион байгуулагдах сургалтанд дотоод аудиторуудын мэдлэг чадварыг сайжруулахад анхаарч УБ хотод найм дахь удаагийн "Монгол улсын Дотоод аудиторуудын форум"-д 4 албан хаагч хамрууллаа. Уг форумаас дотоод аудиторын чиг хандлага, Дотоод аудиторуудын анхаарвал зохих гол эрсдэлүүд, технологийн нөлөө болон хэрэглээ, стандартын өөрчлөлтүүд зэрэг сэдвүүдийн хүрээнд илтгэл мэдээлэл сонсож ажлын чиг баримжааг дээшлүүлсэн байна.</p>	
		Сул орон тоог нөхөх ажлыг зохион байгуулж, албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх				<p>Албаны хэмжээнд Архив бичиг хэргийн эрхлэгч өөрийн хүсэлтийн дагуу 2024.03.29-ны өдрийн Б/08 дугаар тушаалаар ажлаас чөлөөлөгдөж, тус орон тоонд албаны даргын 2024.03.29-ны өдрийн Б/09 дүгээр тушаалаар Б.Золжаргалыг томилж цалин хөлсийг тогтоож хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>Мөн албаны даргын 2024.07.09-ны өдрийн Б/16 дугаар тушаалаар ХШҮХМэргэжилтэн албан тушаалд П.Даваажаргалыг Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хуулийн 67.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 27.1.2 заалт, 44.3 заалт, Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын 3-р хавсралтыг тус тус үндэслэн тушаалаар томилгоо хийж сул орон тоог нөхөж ажилласан байна.</p>	100
<b>Арга хэмжээ 3. Албан хаагчдын ажлын байрны нөхцөл, хангамжийг сайжруулах, үр дүнтэй ажиллах нөхцөл бололцоог хангах хүрээнд:</b>							
3	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл аж төрөх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор нарийн мэргэжлийн эмч нарын	Тухай бүр	Дотоод аудитор-СХШУАБ О.Болормаа	Үйл ажиллагааны зардал	Аймгийн Биеийн тамир спортын газраас зохион зохион байгуулж буй "Хичээллэе-Өрнүүлье-Хэвшье" аяны хүрээнд ажлын өдөр бүр ажлын байрны дасгал хөдөлгөөн хийж, зургаар баталгаажуулан тайланг холбогдох газарт хүргүүлсэн.	100


зөвлөгөө авах, лекц  
уншуулах




Албаны соёлын дэд хорооны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу албан хаагчдад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийлгэхийн зэрэгцээ эрүүл зөв хоололтын эмчийн яриа өглөөний цай

127

					<p>хөтөлбөрт хамруулан 3 өдрийн бариа засал, физик эмчилгээнд Анхны оч ӨЭМТ-д үзүүлж эмчилгээ хийлгэсэн.</p> 	
--	--	--	--	--	--	--

							
--	--	--	--	--	--	--	--

					<p>Мөн албан хаагчдын дархлааг дэмжиж витаминжуулах арга хэмжээг авч ажилласан.</p>  <p>Энхжинмандариваа ӨЭМТ-өөс зохион байгуулсан захиргааны 3-р байрны бүх төрийн албан хаагчдыг хамруулсан биеийн жингийн индекс үзэх, хавдрын маркер тестээр үзэх үзлэг шинжилгээнд албан хаагчдыг бүрэн хамруулсан.</p>	
		<p>Албан хаагчдыг ажиллах нөхцөл, шаардлагатай техник хэрэгслээр ханган ажиллах</p>			<p>Байгууллагын удирдлагын зүгээс ажиллах нөхцөл боломжийг хангах үүднээс албан хаагчдаас гаргаж буй санал хүсэлтийг хүлээн авч албаны дундын өрөөг сургалтаар ашиглуулахаар шийдвэрлэж ажилласан. Үүнд: СХШУАБ О.Болормаагийн 2024 оны 10 сард гаргасан хүсэлтийн дагуу уулзалтын өрөөнд хүүхдэд нь багшаар давтлага өгүүлж ашиглуулсан байна.</p>	100

		Хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, ажлын чадварыг нэмэгдүүлэх зорилгоор ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тогтсон хугацаанд хийлгэж хэвшүүлэх			<p>Албан хаагчид тус бүрдээ өөрсдийн мэдэх ажлын байрны дасгал хөдөлгөөний хийж хэвшлээ. Мөн албан хаагчид өөрсдийн сонирхсон спорт клубт хичээллэж байна.</p> 	100
		Албан хаагчдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах			<p>Албан хаагчдыг Баян-өндөр сумын зааланд 7 хоног бүрийн Даваа гаригийн 20 цагаас 1 цаг заал авч хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор арга хэмжээ авч ажилласан байна.</p> <p>Монгол улсын алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлого, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн нэгд заасан Эрүүл мэндийн бодлогын хүрээнд албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулахаар хөтөлбөрийн нэг арга хэмжээ болгон тусгасан. "Анхны оч" ӨЭМТ-д 2024 оны 10 сард албан хаагчдын эрүүл мэндэд анхаарч томуугийн вакцинд бүх албан хаагчдыг бүрэн хамруулсан байна.</p>	100
		Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагын өндөр насны тэтгэвэрт гарсан			<p>Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д зааснаар Монголын уламжлалт Цагаан сарын баярыг тохиолдуулан 4 ахмад настанд нийт 200,0 мянган төгрөгийн тэтгэмж олголоо.</p>	100

		ахмадуудыг хүлээн авах, хүндэтгэл үзүүлэх			Мөн албанд бүртгэлтэй 1 ахмад настан Т.Хандаагийн 2024.03.27-ны өдөр гаргасан өргөдлийн дагуу эмчилгээний зардалд 150,0 мянган төгрөгийг байгууллагын зардлаас гаргаж нэг удаагийн буцалтгүй тусламжийг албаны даргын 2024.01.24-ны өдрийн А/04 дугаар тушаалаар олгожээ.	
<b>Биелэлтийн дундаж хувь</b>						<b>100%</b>

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ХЯНАСАН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН-ДОТООД АУДИТОР, СХШУБ



Л.БУЛГАНЦЭЦЭГ

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ДОТООД АУДИТОР, СХШУАБ



О.БОЛОРМАА